



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД БОЛОН ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
2025 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ
(ЖИЛИЙН ЭЦЭС)**

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД, ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ
ГЭРЭЭНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

Гэрээ-ний заалт	Заалтын агуулга	Биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5
3.13	Сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 хэсэгт заасныг зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах	<p>2025 онд Аймгийн болон 2 сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан: Дотоод аудитаар 1 зөрчил илэрч, ажил сайжруулах 4 зөвлөмж хүргүүлэн 2024 оны санхүү, үйл ажиллагааг “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” гэж дүгнэсэн. 2. Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан: Дотоод аудитаар 6 зөрчил илэрч, 885,197.5 мян.төгрөгийн 3 зөрчилд зөрчлийг залруулах албан шаардлага, ажил сайжруулах 1 зөвлөмж хүргүүлэн 2024 оны санхүү, үйл ажиллагааг “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” гэж дүгнэсэн. 3. Баян-Өндөр сумын Орон нутгийн хөгжлийн сан: Дотоод аудитыг гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн явц 90%-ийн биелэлттэй. Дотоод аудитаар илэрсэн зөрчил, дотоод аудитын тайлан, дүгнэлтийг Газрын дарга-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчаар хянуулан баталгаажуулж, тус сангууд хариуцсан удирдлага, холбогдох албан хаагчдад танилцуулан ажилласан байна. Мөн дотоод аудитаар илэрсэн зөрчлийг залруулж ажилласан тухай биелэлтийн тайланг албан бичгээр хүлээн авч, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна. 	Байхгүй	Байхгүй

3.40	<p>“Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж, биелэлтийг улирал бүрийн эцэст Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж ажиллана.” заалт</p>	<p>Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн №62/25 дугаартай удирдамжийн хүрээнд “Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр””-ын 2024 оны төсөв санхүү, үйл ажиллагаанд төлөвлөгөөт нийцлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>Дотоод аудитаар нийт 129,700.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснийг шалгалтын явцад залруулж холбогдох тайлбар, анхан шатны баримтын бүрдлийг хангуулан, 1 зөвлөмж өгч ажиллалаа. Зөвлөмж</p> <ol style="list-style-type: none"> 1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилтийг хангах 3. “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийн ажиллах журмыг мөрдөж ажиллах, цаашид илэрсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх <p>Аудитаар “Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд дэмжлэг үзүүлэх “Ажлын хэсгийн ажиллах журам”-ийн хэрэгжилтийг хангаж, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тайлант онд байгууллага, хувь хүмүүстэй тооцоо нийлээгүй, өр авлага бүртгээгүй зэрэг зөрчил илэрсэн тул тус сангийн 2024 оны үйл ажиллагааг “САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ” гэж дүгнэлээ.</p> <p>Тус байгууллагын засаглалын удирдлага, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үйл явцын төлөвшлийг 2 дугаар төвшинд буюу “ТОМЬЁОЛСОН” төвшинд байна гэж үнэлсэн байна.</p>	Байхгүй	Байхгүй
3.41	<p>“Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитуудыг дотоод аудитын чиглэлээр сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулна.” заалт</p>	<p>2025 оны байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын чиглэлээр Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, Дотоод аудитуудыг сургаж, мэргэшүүлэх, дадлагажуулах 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 31 албан хаагчийг хамруулж ажиллалаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. 2025.03.21-ний өдөр Улаанбаатар хотод “Дотоод аудитуудын институт”-тэй гэрээ байгуулж, багш Ж.Жаргалсүрэнгээс Засаглах 	Байхгүй	Байхгүй

		<p>удирдлага, гүйцэтгэх удирдлага, хараат бус дотоод аудитын талаар дэлгэрэнгүй ойлголт авч, “Жаргалант ус, дулаан түгээх станц” ОНӨХК-нд хийсэн дотоод аудитын тайланд үндэслэн дадлага ажил хийж, бодит кейс дээр ажиллан харилцан мэдээлэл солилцож, зөвлөгөө зөвлөмж авсан. Сургалтад 11 албан хаагч</p> <p>2. Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын газраас санаачлан Монгол улсын Сангийн яамтай хамтран 2025.05.30-ны өдөр зохион байгуулсан Дотоод аудитор, СХШУБ (СХШУАБ) нарыг чадавхжуулах, мэдлэг мэдээлэл солилцох “Үзүүлэх сургалт”-д байгууллагын 4 албан хаагч</p> <p>3. Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран 2025.05.29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Хамтын хөгжил-Сайн туршлага” сэдэвт зөвлөгөөнд 2 албан хаагч</p> <p>4. Улаанбаатар хотод 2025.11.13-2025.11.14- ний өдрүүдэд Сангийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран зохион байгуулж “Улсын салбарын дотоод аудиторыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох” зөвлөгөөнд Газрын дарга оролцлоо. Мөн 10 албан хаагч цахимаар хамрагдлаа.</p> <p>5. Улаанбаатар хотод 2025.11.19-ны өдөр зохион байгуулагдсан “Дотоод аудиторын форум”-д 3 албан хаагч</p>		
3.42	<p>“Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорсоны дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв</p>	<p>Аймгийн Дотоод аудитын хорооны хурлыг хагас, бүтэн жилээр 2 удаа зохион байгуулдаг.</p> <p>1. Тайлант оны эхний хагас жилийн хурлыг 2025.04.30-ны өдөр зохион байгуулж, 3 асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Засгийн газрын 2025 оны 37 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг “Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар” болгон өөрчилсөнтэй холбоотой Газрын дүрэм, Дотоод аудитын журам, Санхүүгийн хяналт шалгалт хийх журамд өөрчлөлт оруулан батлуулсан. ➢ Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагналаа. (2024 оны нэгдсэн танилцуулга) 	Байхгүй	Байхгүй

	байгууллагад хүргүүлнэ.” заалт	<p>➢ 2025 оны Дотоод аудит, хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд 2025.03.30-ны өдрийн байдлаар Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан 9 байгууллагын шалгалтын дүнг танилцууллаа. (түүвэрт хамрагдсан 9 байгууллагын танилцуулга)</p> <p>2. Тайлант оны жилийн эцсийн хурлыг 2025.12.26-ны өдөр хуралдуулах тов гарсан.</p>		
3.43	“Дотоод аудитын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх, дотоод аудит санхүүгийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэх, шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлж ажиллана.” заалт	<p>2025 онд системийн хөгжүүлэлт зогссоны улмаас тус системд мэдээлэл байршуулаагүй болно.</p> <p>Энэ онд газрын хэмжээнд 14.5 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэн суурийн компьютер 3 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, суурийн компьютерын дэлгэц 2 ширхэг олон үйлдэлт өнгөт принтер 1 ширхэг, олон үйлдэлт хар принтер 2 ширхгийг худалдан авч, албан хаагчдын ажил үүргээ хурдан шуурхай гүйцэтгэх нөхцөлийг сайжруулж, байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж ажилласан.</p> <p>2025 онд Эрсдэлийн менежментийн ISO 31000:2018 Олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, дотоод аудит, санхүү хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудын 10 жилийн “Нэгдсэн бүртгэл”-ийг GOOGLE FORMS дээр шивж, нэгтэх ажил хийсэн.</p>	Байхгүй	“Дотоод аудитын удирдлагын мэдээллийн систем ажиллахгүй байгаа.
Хэрэгжилтийн дундаж хувь			100%	

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД АУДИТОР-
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

Д.САЙЗМАА

Л.БУЛГАНЦЭЦЭГ